

Багш мэргэжлийн тасралтгүй хөгжлийн өнөөгийн байдал (Баримт бичгийн судалгаа)

У.Туяа^а, О.Оюунтунгалаг^б, Б.Нацагдорж^{с*}

^аБоловсролын хүрээлэн, Үндэсний цөөнх болон гадаад дахь монгол хүүхдийн судалгааны сектер

^бБагшийн мэргэжил дээшлүүлэх институт, захиргаа

^сБагшийн мэргэжил дээшлүүлэх институт, Багшийн хөгжил сургалтын технологийн алба

Хураангуй

Уг баримт бичгийн шинжилгээгээр багш мэргэжлийн тасралтгүй хөгжил, өнөөгийн байдлыг бодлогын зарим баримт бичигт хэрхэн тусгасан, мөн олон улсад болон Монгол улсад багш мэргэжлийн тасралтгүй хөгжлийн асуудлаар ямар хавсарга судалгаа хийж, үр дүнд хүрэв гэдгийг чанарын судалгааны аргыг ашиглаж судлав. Судалгааг боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн төв байгууллагын судлаачид хамтран гүйцэтгэв.

Судалгааны зарим үр дүнгээс үзэхэд багш мэргэжлийн тасралтгүй хөгжлийн талаарх ойлголт, хандлага судлаачдын түвшинд өөр өөр байгаа хэдий ч насан туршийн суралцах үйл гэсэн хандлагад байр суурьт нэгдэж байна. Багшийн хэрэгцээ шаардлагыг хангахад чиглэсэн багш, сургууль, мэргэжлийн байгууллагын үйл ажиллагааны чиглэл, тэдний тасралтгүй хөгжлийг дэмжих арга замыг цаашид нарийвчлан судлах шаардлагатай байгаа нь баримт бичгийн шинжилгээний үр дүнгээс ажиглагдаж байна.

Түлхүүр үг

Мэргэжлийн тасралтгүй хөгжил, хандлага, судалгаа

Удиртгал

Багш мэргэжлийн тасралтгүй хөгжил (БМТХ) нь сургалтын чанарт нөлөөлөх томоохон хүчин зүйл бөгөөд шинжлэх ухаан, технологийн хөгжил, дэвшлийн нөлөөгөөр асар хурдтайгаар хувьсан өөрчлөгдөж буй нийгэмд дэлхийн өндөр хөгжилтэй улсууд багш мэргэжлийн тасралтгүй хөгжлийн талаарх ойлголтоо нэгтгэж, багш мэргэжлийн тасралтгүй хөгжих хэрэгцээг тодорхойлоход онцгой ач холбогдол өгч энэ чиглэлийн судалгааг ихээхэн дэмждэг болжээ. Олон улсын эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллага (OECD) зарим гишүүн орнуудаа хамруулан багш мэргэжлийн тасралтгүй хөгжлийн хэрэгцээний судалгаа хийсэн нь энэ төрлийн судалгаа хийх зайлшгүй шаардлага байгааг харуулж байна. Мөн боловсролын чанараар тэргүүлэгч орнууд болох Англи, Америк, Ирланд, Норвеги зэрэг улсууд ч энэ төрлийн судалгааг тогтмол хийдэг нь багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжил боловсролын чанар хооронд ач холбогдолтой хамаарал байгааг илтгэж байна.

Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2012 оны А/136 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар “Багшийн хөгжил” хөтөлбөрийг баталсан бөгөөд

бүх шатны боловсролын байгууллагын багшийн мэргэжил дээшлүүлэх хэрэгцээний судалгааг үндэсний түвшинд үйл ажиллагаа явуулж буй мэргэжил арга зүйн байгууллагууд хамтран хийх болсон. Энэ ажлын хүрээнд “Багш мэргэжлийн тасралтгүй хөгжих хэрэгцээ” судалгааг Багшийн мэргэжил дээшлүүлэх институт Боловсролын хүрээлэнгийн судлаачидтай хамтран 2015-2016 онд гүйцэтгэв. Судалгааны багт ажилласан судлаачид хамтран судалгааны ажлын үр дүнг боловсролын салбарын судлаач, багш, олон нийтэд танилцуулах үүднээс цуврал байдлаар өгүүлэл болгон нийтлүүлж байгаа бөгөөд энэ удаад баримт бичгийн судалгааны зарим үр дүнгээс хуваалцаж байна.

Судалгааны арга зүй

Судалгааны зорилго: Багш мэргэжлийн тасралтгүй хөгжлийн талаарх зарим бодлогын баримт бичгүүд, олон улсын болон Монгол улсын хэмжээнд хийсэн судалгааны тайланд шинжилгээ хийх

Бодлогын баримт бичигт бид Боловсролын тухай хууль (2002), Бага, дунд боловсролын тухай хууль (2002), Бага, дунд боловсролын чанарын шинэчлэлийн үзэл баримтлал (БШУ-ны сайдын

* ✉ natsagdorj@itpd.mn

2013 оны А/155 дугаар тушаал), Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын сургалтын байгууллагын багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх журам (БШУ-ны сайдын 2013 оны А/287 дугаар тушаал), Аймаг, нийслэлийн боловсролын газрын үлгэрчилсэн журам (БШУ-ны сайдын 2013 оны А/315 дугаар тушаал), “Багшийн хөгжил хөтөлбөр” (2012.11.22 өдрийн А/136 тоот тушаалын хавсралт), 2013 онд Багшийн мэргэжил дээшлүүлэх институт Боловсролын Хүрээлэнтэй хамтран хийсэн “Багшийн хөгжих хэрэгцээ” судалгааны тайлан, “Багш мэргэжлийн стандартын харьцуулсан судалгаа-2011” (МУБИС), Багш мэргэжлийн тасралтгүй хөгжил: ОУ-ын чиг хандлага, туршлагын харьцуулсан судалгаа (2013-Багшийн мэргэжил дээшлүүлэх дэд баг-МУБИС) зэрэг эх материалуудыг харьцуулж судлав.

Судалгааны арга

Дээрх бодлогын баримт бичгүүдийг судлахдаа чанарын судалгааны арга болох ярилцлагын болон контент анализын аргуудад тулгуурлан судалгааны мэдээллийг цуглуулж, боловсруулалтыг хийхдээ задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх аргуудыг ашиглав.

Нэг. Багш мэргэжлийн тасралтгүй хөгжлийн талаарх олон улсын зарим судалгаа

Өнөөгийн боловсролын олон улсын чиг хандлага багш боловсролыг цогцоор нь (teacher education continuum) буюу багш бэлтгэх (initial teacher education)-тодорхой хугацаанд туршлагажих (induction)-мэргэжлийн тасралтгүй хөгжлийг хангах (continuing professional development) гэсэн хоорондоо нарийн холбоо, уялдаа бүхий шаталсан тогтолцоог бий болгохоор зорьж байна. Үүнд, ирээдүйн багшийг суралцагчдын өдрөөс өдөрт өсөн нэмэгдэж буй сурах хэрэгцээг хангаж тэдгээрийн сурах үйлийг чадваржуулах талаас нь зохион байгуулах мэдлэг, туршлагатай, мөн өөрийн мэргэжлийн хөгжлийг хангахуйц насан туршдаа суралцах чадвартай сайн багш болгон төлөвшүүлэхэд мэргэжлийн тасралтгүй хөгжлийн тогтолцооны үүрэг чухлаар тавигдаж байна.

Багш мэргэжлийн тасралтгүй хөгжлийг (Continuing professional development (CPD) багш нарыг боловсролын олон талт үйл ажиллагаанд хамруулан тэдгээрийн мэргэжлийн мэдлэг, ойлголт, чадварыг баяжуулах насан туршийн суралцах үйл хэмээн ойлгох хандлагатай байна.

“Мэргэжлийн тасралтгүй хөгжил” хэмээх ойлголтыг тодруулбал,

- Мэргэжлийн: багшид зайлшгүй шаардагдах мэдлэг, чадварыг хөгжүүлэх, туршлага хуримтлуулахад чиглэсэн үйл ажиллагаа (Байгалмаа, 2013, х.22)
- Тасралтгүй: насан туршийн мэргэжлийн хөгжил талаас багш нар мэддэг, эсвэл сурсан зүйлийнхээ талаар эргэцүүлэн цаашид ямар мэдлэг, чадвар олж авах хэрэгцээ, шаардлага байгаагаар тодорхойлох, туршин хэрэгжүүлэх циклээр явагддаг үйл
- Хөгжил: тавьсан зорилгод хүрсэн, эсвэл шаардлагад хэрхэн нийцэж байгаа талаас бус, харин сурган хүмүүжүүлэх практик үйл ажиллагааг шинэчлэх, хөгжүүлэх талаас ямар үр өгөөжтэй байгаагаар тодорхойлогдох үйл

Англи улсад “Мэргэжлийн тасралтгүй хөгжил гэдэг нь багш, сургалтын менежерүүдэд ажлын байран дээр үүсэж буй шинэ сорил, бэрхшээлийг шийдэх арга замыг хайх, ажлын гүйцэтгэлээ сайжруулах, зорилгодоо хүрэхэд нь дэмжлэг үзүүлэх үйл явц юм” (Их Британи улсын багш мэргэжлийн тасралтгүй хөгжил), Ирландад “Мэргэжлийн тасралтгүй хөгжил гэдэг нь хувь хүн мэдлэг, туршлагаа дээшлүүлэх, албан болон албан бус сурах үйл ажиллагааны цогц юм” гэж тодорхойлсон бөгөөд мөн багш мэргэжлийн тасралтгүй хөгжлийг дэмжих үйл ажиллагаанд тухайн багшийн сонголт, сонирхол, үүрэг хариуцлага хамгийн чухал бөгөөд багшийн мэргэжил дээшлүүлэх үйл ажиллагааны зорилго нь багшийн ур чадварыг дээшлүүлэх, үндэсний сургалтын хөтөлбөрийн өөрчлөлтийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, багш нарыг сэдэлжүүлэхэд чиглэсэн байдаг гэжээ.

Сургалтын суурь үндэс болсон багш мэргэжлийн тасралтгүй хөгжлийг Азийн боловсролын загвар орны нэг болох Сингапур улсын Боловсролын Үндэсний Хүрээлэн “XXI зууны багшийн загвар”-т авч үзэхдээ, хүүхэд төвт үнэт зүйлсийг баримжаалан:

- “Хэрвээ би сурагч байсан бол энэ нөхцөлд ямар байх байсан бэ” гэдэгт хариулан өөрийгөө суралцагчдын нөхцөлд тавих
- Суралцагч бүрд суралцах чадвар бий гэдэгт итгэх
- Тэдний ялгаатай байдлыг үнэлэх Мөн багш өөрийгөө хөгжүүлэхдээ:
- Өндөр стандарт бүхий зорилтууд
- Судлан шинжлэх мөн чанар
- Суралцах эрмэлзэл
- Өөрийгөө хөгжүүлэх чармайлт
- Хүсэл тэмүүлэл

1 Going forward Continuing Professional Development for Teachers

- Дасан зохицох ба уян хатан чадвар
- Мэргэжлийн ёс зүй зэрэгт анхаарч Хамтын ажиллагаанд суурилсан:
- Хамтран суралцах ба ажиллах
- Дагалдах ба зөвлөн чиглүүлэх
- Нийгмийн хариуцлага ба үүрэг хүлээж байх үед илүү хөгждөг гэж үзсэн байна.

Дэлхийн улс орнуудад БМТХ-ийн үйл ажиллагааны олон хэлбэр хэрэглэгдэж байгаа бөгөөд эдгээрийг зохион байгуулагдаж буй хамаарлаар нь гурав ангилж үздэг. (Бурмаа, ба бус, 2013, х.6)

Үүнд:

1. Сургуульд суурилсан:
 - Сургуулийн нийт багшийн сургалт
 - Шинэ багшийн туршилтын сургалт
 - Дагалдуулан сургах
 - Хичээлийн ажиглалт, хэлэлцүүлэг
 - Үйл ажиллагааны хамтын төлөвлөлт, үнэлгээ
 - Багшийн өөрийн үнэлгээ
 - Бусад багштай зөвлөх, хамтран хэлэлцэх
 - Багшлах үйлийн судалгаа
2. Сургууль хоорондын хамтын үйл ажиллагаа:
 - Бусад сургуульд айлчлах, туршлага судлах
 - Хурал, зөвлөгөөнд оролцох
 - Бусад сургуультай хамтран сургалт, туршилт зохион байгуулах
 - Багшийн мэргэжлийн холбоонд гишүүнээр элсэх
 - Заадаг хичээлээр нэгдэх
3. Сургуулийн хүрээнээс гадуурх үйл ажиллагаа:
 - Олон нийтийн болон бизнесийн байгууллагаас зохион байгуулсан сургалт
 - Их сургуулиас зохион байгуулсан сургалтад хамрагдах
 - Нэгдсэн шалгалтуудад ажиллах (шалгагч багшийн сургалтад хамрагдах)
 - Онлайн сургалтад хамрагдах
 - Солилцооны хөтөлбөрт хамрагдах
 - Мэргэжлийн ном зохиол, бүтээл судлах

Олон улсад БМТХ-ийн үйл ажиллагааг зохион байгуулж ирсэн 9 загвар байдаг бөгөөд эдгээрийг ямар түвшинд хэрэгжүүлж байгаад шинжилгээ хийх нь чухал ач холбогдолтой юм.

Хүснэгт 1
Багш мэргэжлийн тасралтгүй хөгжлийн загварууд

Мэргэжлийн тасралтгүй хөгжлийн загварууд	Загварын зорилго	
-Сургалтын загвар -Зэрэг олгох загвар -Хэрэгцээний загвар -Каскад загвар	Дамжуулах (transmission)	Бие даасан мэргэжилтэн бий болгох
-Стандартад суурилсан загвар -Дагалдуулан сургах загвар -Мэргэжлийн хамтлагийн загвар	Шилжилтийн (transitional)	↓
-Үйлийн судалгааны загвар -Практикийг өөрчлөх загвар	Практик үйлийг өөрчлөх (transformative)	

Олон улсын суралцагчдын үнэлгээний /PISA/ хөтөлбөрөөр тэргүүлэгч Финланд улсын дэлхийд танигдсан боловсролын амжилтын цаана багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжил байдаг бөгөөд багш бүр өөрийгөө хөгжүүлэхдээ доорх мэдлэг, чадварт баримжаалан ажлын байрандаа хөгждөг гэж зарим судлаач тэмдэглэсэн байна.

Үүнд:

- Багш нарын хамтын ажиллагаа
- Боловсрол судлалын онол болон заадаг хичээлийн агуулгын талаарх мэдлэг
- Багш бүр судалгаа шинжилгээ хийх замаар өдөр тутмын сургалтын үйл ажиллагаагаа сайжруулах
- Өөрийн болон бусдын сургалтын үйл ажиллагаанд ажиглалт хийж, туршлагаа хуваалцаж, сургалтын хөтөлбөрөө байнга сайжруулж боловсруулах
- Мэргэжлийн өндөр хариуцлага
- Танхимын сургалт болон мэргэжлийн хамтын ажиллагааг өндөр хэмжээнд зохион байгуулах зэрэг болно.

Хоёр. Багш мэргэжлийн тасралтгүй хөгжлийн асуудлыг дотоодын эрх зүйн баримт бичигт тусгасан байдал, Монгол улсад хийгдсэн зарим судалгаа

Багш мэргэжлийн тасралтгүй хөгжлийн хэрэгцээг “Багшийн хөгжил хөтөлбөр” (2012 оны А/136 дугаар тушаалын хавсралт), 2013 онд Багшийн мэргэжил дээшлүүлэх институт Боловсролын Хүрээлэнтэй хамтран хийсэн “Багшийн хөгжих хэрэгцээ” судалгааны тайлан, “Багш мэргэжлийн стандартын харьцуулсан

судалгаа-2011” (МУБИС), Багш мэргэжлийн тасралтгүй хөгжил: ОУ-ын чиг хандлага, туршлагын харьцуулсан судалгаа (2013-Багшийн мэргэжил дээшлүүлэх дэд баг-МУБИС) зэрэг судалгааны тайланд багш мэргэжлийн тасралтгүй хөгжлийн хэрэгцээг хэрхэн тодорхойлж байгаад харьцуулж судлав.

Багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжлийн тухай “Багшийн хөгжлийн хөтөлбөр”-ийн зорилгод “Ажлын байранд тасралтгүй хөгжих, нөхцөл бүрдүүлэх, хүүхдийг хөгжүүлдэг багш төлөвшүүлэх, тэргүүн туршлагыг түгээх, нэр хүндийг нь өсгөх” гэж тодорхойлсон байхад “Багш мэргэжлийн тасралтгүй хөгжил: ОУ-ын чиг хандлага, туршлагын харьцуулсан судалгаа”-ны тайланд “... мэдлэг, ойлголт, чадварыг баяжуулах насан туршийн суралцах үйл” гэж өргөн утгаар авч үзжээ.

Боловсролын тухай хууль, Бага, дунд боловсролын тухай хууль, Бага, дунд боловсролын чанарын шинэчлэлийн үзэл баримтлал, Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын сургалтын байгууллагын багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх журам, Аймаг, нийслэлийн боловсролын газрын үлгэрчилсэн журам зэрэг хууль, эрх зүйн актад багш мэргэжлийн тасралтгүй хөгжлийн талаар хэрхэн тусгагдсан байгаад шинжилгээ хийж үзэхэд багш мэргэжлийн тасралтгүй хөгжлийн талаарх бодлого боловсролын салбарын эрхзүйн баримт бичгүүдэд багагүй тусгагдсан байна гэж үзэж болохоор байна. Тухайлбал, Бага, дунд боловсролын чанарын шинэчлэлийн үзэл баримтлалын 4.2-т “Багш бүрийг мэргэжил, арга зүй, ур чадвараа системтэй, тасралтгүй дээшлүүлэх тэгш боломжоор хангах сонголттой, нээлттэй, уян хатан, тасралтгүй үйлчилгээ авах тогтолцоо бүрдүүлэх”, Багшийн хөгжил хөтөлбөрийн зорилгод “... багшийн мэргэжлийн ур чадварт тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэн, ажлын байрандаа тасралтгүй хөгжих таатай нөхцөлийг бүрдүүлэх”, “Зөв монгол хүүхэд үндэсний хөтөлбөр”-ийн 6.4.9-т “... багш, удирдах ажилтан бүрийг мэргэжил, арга зүй, ур чадвараа дээшлүүлэх тэгш боломжоор ханган сонголттой, нээлттэй, уян хатан, тасралтгүй үйлчилгээ авах тогтолцоог бүрдүүлнэ” гэж тус тус заажээ. Эдгээр эрх зүйн баримт бичгийн зохицуулалтуудаас үзэхэд багш мэргэжлийн тасралтгүй хөгжлийн асуудлыг тогтолцооны талаас нь нийтлэг байдлаар тусган хэрэгжүүлсэн байна гэж үзэж болохоор байна.

Судалгааны зарим үр дүн

- Өнөөгийн боловсролын олон улсын чиг хандлага багш боловсролыг цогцоор нь буюу багш бэлтгэх, тодорхой хугацаанд туршлагажих, мэргэжлийн тасралтгүй хөгжлийг хангах гэсэн циклээр хоорондоо нарийн холбоо, уялдаа бүхий шаталсан тогтолцоог бий болгохоор зорьж байна.
- Багш мэргэжлийн тасралтгүй хөгжил гэдгийн дор багш нарыг боловсролын олон талт үйл ажиллагаанд хамруулан тэдгээрийн мэргэжлийн мэдлэг, ойлголт, чадварыг баяжуулах насан туршийн суралцах үйл хэмээн тодорхойлж байна.
- Дэлхийн улс орнуудад багш мэргэжлийн тасралтгүй хөгжлийг дэмжих боловсролын олон талт үйл ажиллагаа, арга хэлбэр хэрэглэгдэж байгаа бөгөөд эдгээрийг зохион байгуулагдаж буй хамаарлаар нь 1) Сургуульд суурилсан үйл ажиллагаа 2) Сургууль хоорондын хамтын үйл ажиллагаа 3) Сургуулийн хүрээнээс гадуурх үйл ажиллагаа хэмээн ангилан үзэж байна.
- Багш мэргэжлийн тасралтгүй хөгжлийн үйл ажиллагааг зохион байгуулж буй хэд хэдэн загварыг судлаачдын түвшинд авч үзэж байна.
- Багш мэргэжлийн тасралтгүй хөгжлийн асуудлыг эрх зүйн баримт бичгүүдэд нийтлэг байдлаар тусган өгсөн гэж үзэж болохоор байна. Тухайлбал, Багшийн хөгжил хөтөлбөр болон Багшийн мэргэжил дээшлүүлэх сургалт-арга зүйн байгууллагын дүрэмд зарим үйл ажиллагаануудыг тодорхой зааж өгсөн байна. Мөн холбогдох төрийн захиргааны төв болон орон нутгийн мэргэжил арга зүйн байгууллагуудын чиг үүрэгт багшийн мэргэжлийн хөгжлийн хэрэгцээг хангах чиглэлээр холбогдох заалт, эрх зүйн зохицуулалтуудыг тусган өгсөн байна.

Дүгнэлт

Багш мэргэжлийн тасралтгүй хөгжлийн талаарх зарим бодлогын баримт бичгүүд, олон улсын болон Монгол улсын хэмжээнд хийсэн судалгааны тайланд чанарын шинжилгээ хийж дараах дүгнэлтэд хүрэв.

1. Багш мэргэжлийн тасралтгүй хөгжлийн асуудлыг бодлогын баримт бичигт тодорхой хэмжээгээр тусган өгсөн байна.
2. Багшийн мэргэжил дээшлүүлэх сургалт-арга зүйн байгууллага бусад боловсролын

- мэргэжил арга зүйн байгууллагуудтай хамтран багшийн хөгжлийн асуудлаар судалгааны ажлуудыг хийж эхэлсэн байна.
3. Багш мэргэжлийн тасралтгүй хөгжлийн талаарх ойлголт өнөөдөр судлаачдын түвшинд харилцан адилгүй байгаа бөгөөд мэргэжлийн тасралтгүй хөгжлийг ихэнхдээ “сургалт”-ын үйл ажиллагаатай холбогдуулан үзсэн байна.
- Санал, зөвлөмж**
- Багш мэргэжлийн тасралтгүй хөгжлийн талаарх бодлого, эрх зүйн зохицуулалтыг сайжруулах
 - Багш мэргэжлийн тасралтгүй хөгжлийг зөвхөн сургалтаар хязгаарлахгүй багшийн хөгжлийг дэмжих олон талт үйл ажиллагаагаар ойлгох
 - Багш мэргэжлийн тасралтгүй хөгжлийг хангах хүрээнд ажиллаж буй байгууллагуудын чиг үүргийн эрэмбэ, ялгаа, уялдаа холбоог сайжруулах
- Ашигласан материал**
- Монгол Улсын Үндсэн хууль 1992. (УИХ).
Улаанбаатар.
- Боловсролын тухай хууль 2002. (УИХ).
Улаанбаатар.
- Бага, дунд боловсролын тухай хууль 2002. (УИХ).
Улаанбаатар.
- Боловсрол, Шинжлэх ухааны яам. (2013).
Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын сургалтын байгууллагын багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх журам. Улаанбаатар
- Боловсрол, шинжлэх ухааны яам. (2013). Багшийн хөгжил хөтөлбөр. Улаанбаатар
- Байгалмаа, Ч. (2013). Багш мэргэжлийн хөгжил туршилт судалгаа. Улаанбаатар: Битпресс
- Бурмаа, Б. (2013). Багш мэргэжлийн тасралтгүй хөгжил: ОУ-ын чиг хандлага, туршлагын харьцуулсан судалгааны тайлан. Улаанбаатар
- Joanne, B. (2012). Evaluating the Impact of Continuing Professional Development. Washington
- Continuous Professional Development among Primary Teachers in Ireland. (2009). Organisation for Economic Co-operation and Development study report. Ireland
- British Council. (2012). Going forward Continuing Professional Development for Teachers in the UK. United Kingdom

Current state of the Teacher's continuous professional development

(Research on documentation)

U. Tuya^a, O. Oyuntungalag^b, B. Natsagdorj^c

^aInstitute of Education, National minority and research sector for Mongolian children abroad

^bAdministration department, Institute of Teacher's professional development

^cInstitute of Teacher's professional development, Department of Teacher's development training technology

Abstract

The paper is designed to examine how the extent to which the concept of continuing teacher development and approaches are reflected in policy documents while carrying out some studies. In using qualitative research methods, applied research was conducted on continuing teacher education in Mongolia and abroad as well. The research was conducted jointly by the scholars of the Center for Educational Research and Methodology.

According to some research findings, although researchers have different perspectives on the perceptions and attitudes towards continuing teacher education, they share a common position an perception of lifelong learning. Furthermore, it is evident from the results of the analysis that there is a need to study the further perspectives and tendencies on activities of teachers, schools and professional organizations in order to meet the teacher needs and demands; and to find the ways to support their continuing development.

Key words

Continuous professional development, trend and research